



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/507

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Си Ти Эс ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.0.1 программыг ашиглаж эхэлсэн Буянт, Ховд, Эрдэнэбүрэн сум, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын нягтлан бодогчдын бүх төрлийн төсвийн хөрөнгө оруулалтыг бүртгэн тайлагнах сургалт болон програмыг ашиглах ажиллагааг дадлагажуулах арга хэмжээний зардалд 600.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Тус арга хэмжээнд зарцуулах 600.0 мянган төгрөг /зургаан зуун мянган/-ийг аймгийн хөрөнгө оруулалтын захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/507 дугаар захирамжийн хавсралт



СУРГАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /мянган төгрөгөөр/
1	Сургалт /10 цаг/	хүн	12	50000.00	600.0
	Дүн				600.0

-оОо-